



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/477

Ховд

Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Бүтээмж тауэр" ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Засаг даргын Тамгын газрын барилга /Ховд, Чандмань сум/-ын ажилд ашиглагчийн хүсэлтийн дагуу ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлтээр хийгдэх ажлыг нягтлан шалгаж, нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч: Б.Ганболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

З.Онолбаатар - Чандмань сумын Засаг дарга

Ц.Дашмягмар - "Бүтээмж тауэр" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн
дарга Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилга, хот байгуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Ганболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Zah A/477 Kh1